

**ДОРНОД АЙМГИЙН МУЗЕЙ**

Д/д	Үзмэрийн нэр	Хувийн дугаар	Тоо ширхэг	Хэмжээ	УБМС-ийн дугаар РСН (прораммын)	Судлагдсан сурталчлагдсан байдал	Саналын үндэслэл
1	Шивэргэл /үзэмчин/	70.94	1иж 2ш	Урт: 110см,  Жин: 430гр, Хэмжээ: 70.94.2: Урт-110см Жин-430гр	2101ДОМ0148 9	1.Монголын угсаатны зүй УБ хот,1987, 1-р боть 2.Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин эхнэр хүний гоёл чимэглэлийн төрөл шивэргэл /ширгүүл/ юм. Үзэмчин эхнэрүүд эрт үеэс үсээ хоёр салаалан сүлжээд түүдэглэн боож, түүдэгээ ширгүүл хэмээх үсний уутад хийж доош унжуулан зүүдэг байна. Энэхүү эд өлгийн зүйл нь хийц загварын хувьд түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
2	Сүйх /үзэмчин/	70.96	1иж 3ш	Жин: 1120гр, Хэмжээ: Урт-35,5см	2101ДОМ0148 9	1.Монголын угсаатны зүй УБ хот,1987, 1-р боть 2.Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин эхнэрийн сүйх эхнэр хүнийг охидоос ялгана. Үзэмчин эхнэрүүд гол төлөв бага зургаан мөнгө мөнгөн сүйхийг өргөн хэрэглэж иржээ. 8 тахилын хээгээр чимэглэсэн байдаг. Ийнхүү Үзэмчин эхнэр хүний гоёл чимэглэлийн төрөл сүйх нь гурван сагалдрага бүхий, хэрэглэгдэхүүнийг мөнгөөр урласан, дахин давтагдашгүй гоёл чимэглэлийн урлагийн бүтээл, урт 34 см, хүндийн жин 1120 гр, энэхүү эд өлгийн зүйл нь хийц загварын хувьд түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
3	Шүрэн татуур /үзэмчин/	70.92	1	Жин: 890гр	2101ДОМ0144 0	1.Монголын угсаатны зүй УБ хот,1987, 1-р боть 2.Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин эхнэрүүд магнайвч буюу “татуур” хэмээх шүрэн гоёлыг өргөнөөр хэрэглэж байжээ. Хар өнгийн даавуун дээр торгон дээр пааландсан хээтэй чимэг хадаж шүр шигтгэсэн татуургыг зулай 3 ширхэг мөнгөн товчоор товчилж тогтооно. Татуурганаас унжлага гэх олон жижиг хэлхэн торлосон шүрэн тор хэлхэж мөнгөн чимэг бүхий олон жижиг шүрийг 10 салаа болгон хоёр талаар нь унжуулна. Материал мөнгө, шүр, хүндийн жин 895

							гр. Уг дурсгал нь үзэмчин эхнэр хүний гоёл чимэглэлийн төрөл шүрэн татуур арван таван хадлага, чамархайн унжлага хоёр ширхэг шүртэй, хадлагыг тойруулаад жижиг шүрэн шигтгээтэй. Энэхүү эд өлгийн зүйл нь хийц загварын хувьд түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
4	Гуу /үзэмчин/	70.93	1иж 2ш	Жин: 480гр, Хэмжээ: Диаметр-8,5см өндөр-3,2см Том шүр 5,4х5,5см	2101ДОМ0144 2	Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин эхнэр хүний гоёл чимэглэл, бурхан шүтээний холбогдол бүхий, дурсгалын их биеийн хэсгийн голын хэсэгт том шүртэй, зүүлтэнд таван ширхэг улаан шүр бүхий, дөрвөн ширхэг хув, зургаан ширхэг шүр, хоёр ширхэг оюутай. Энэхүү эд өлгийн зүйл нь чимэглэлийн урлагийн онцлогийг харуулсан, хийц загварын хувьд түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
5	Хажуугийн зүүтгэл /үзэмчин/	70.95	1иж 2ш	70.95.1 Урт: 68см, Жин: 795гр, 70.95.2: урт-65см жин-720гр	2101ДОМ0148 7	Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин эхнэр хүний гоёл чимэглэлийн төрөл хажуугийн зүүтгэл бэл хоёр ширхэг, зүүвч тээг хоёр ширхэг, пааландаж урласан тээг дээр арслангийн дүрс сийлбэрлэн чимэглэсэн, бэл нь хоёр ширхэг шүрэн шигтгээ бүхий, дөрвөн унжлага таван ембүүтэй, нийт 13 ширхэг гинжэн унжлага чимэглэлтэй. Энэхүү эд өлгийн зүйл нь чимэглэлийн урлагийн онцлогийг харуулсан, хийц загварын хувьд түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
6	Малгай /Үзэмчин/	70.100	1	Өндөр: 16см, Хэмжээ: Тойрог-70см Бүч урт-39см Хүрээ өндөр-13см	2101ДОМ0148 4	Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин ястны уламжлалт гадуур хувцасны төрөл малгай нь хар сор бүхий үнэт ангийн өргөн хүрээтэй. Ийм загварын малгай ховор бөгөөд тухайн цаг үеийн өгүүлэх түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.

7	Ууж /Үзэмчин/	70.98	1	Урт: 118см, Хэмжээ: Цээж өргөн-27,5см ар оноо -67 см Хажуу оноо-67см	2101ДОМ0098 0	Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин ястны эхнэр хүний уламжлалт гадуур хувцасны төрөл ууж нь хоргой торгон эмжээр бүхий, хар торгон ёсны хувцас болно. Энэхүү эд өлгийн зүйл нь хийц загварын хувьд түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
8	Дээл /Үзэмчин/	70.97	1	Урт: 124см, Өргөн: 37см, Хэмжээ: Ханцуй урт-97 см өргөн-15см Суга өргөн-25см нудрага урт-15 см өргөн-18,5см Зах урт-40 см өндөр-9 см оноо урт-41 см	2101ДОМ0004 1	Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүтгэл” Чойбалсан хот 2011 он	Үзэмчин ястны эхнэр хүний уламжлалт гадуур хувцас дээлийг ягаан өнгийн чирчүү материалаар урласан, хоёр хажуудаа оноотой, өргөн хар эмжээр бүхий, босоо өндөр захтай, хөх нударгатай. Энэхүү эд өлгийн зүйл нь үзэмчин ястаны уламжлалт дээлийн хэв загварыг харуулж өгснөөрөө онцлог юм. Энэхүү эд өлгийн зүйл нь хийц загварын хувьд түүх соёлын ховор нандин үзмэрт багтах үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
9	Гутал /үзэмчин/	70.99	1иж 2ш	Өндөр: 36см, Хэмжээ: Ул урт- 28см Өргөн-9,5см	2101ДОМ0004 0	Х.Санжаасүрэн “Үзэмчин эхнэрийн хувцас зүүсгэл” Чойбалсан хот 2011 он	Хар өнгийн булигаараар хийсэн, ногоон эмжээртэй, түрүүний ар талд үдээсний нүхтэй, ширж оёсон ширэн ултай үзэмчин гутал. Ийм загварын гутал ховор бөгөөд тухайн цаг үеийн өгүүлэх түүх соёлын чухал ач холбогдол бүхий үзэмчин эхнэрийн иж бүрэн хувцас, зүүтгэлийн нэг юм.
<b>НИЙТ 9 ДЭСИЙН 9 ШИРХЭГ ҮЗМЭР</b>							